



МОНГОЛБАНК

ГАДААД УЛСАД ЭМЧЛҮҮЛЭГЧ ИРГЭДИЙН ЗАРДЛЫН СУДАЛГАА¹

Хураангуй

2011-2014 онд гадаад улсруу эмчлүүлэх зорилгоор аялсан Монгол иргэдийн зарцуулсан нийт зардлын дүнг тодорхойлж, цаашид төлбөрийн тэнцлийн статистикт ашиглагдах эмчилгээний зардлын таамаг тооцоог шинэчлэх зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэв.

Судалгааны хүрээнд Гадаад улсад суугаа элчин сайдын яамд, Эрүүл мэнд, спортын яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, гадаадын эмнэлгийн төлөөлөгчийн газруудаас түүвэр судалгаа авч мэдээллийг банкуудын гадаад гүйлгээний тайлангийн дүнтэй харьцуулан шинжилж, нэмэлт тооцооллыг хийсэн.

2011-2014 онд гадаад улсруу эмчлүүлэх зорилгоор аялсан Монгол иргэд хамгийн багадаа жилд дунджаар 58 сая ам.долларыг зарцуулсан бөгөөд ихэвчлэн БНСУ, БНХАУ, Энэтхэг, Тайланд улсруу аялсан байна.

2015 оны 3-р улирал

Судалгаанд ашигласан нэрний товчлол

¹Монголбанкны ВЭЗГ-ын ТТССХ-ийн эдийн засагч Б.Мөнх-Эрдэнэ, 327088, bmunkherdene@mongolbank.mn



ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭМСЯ	Эрүүл мэнд, спортын яам
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМХХИ	БНСУ-ын Эрүүл мэнд, худалдаа, хөгжлийн институт
ЭСЯ	Элчин сайдын яам
ITRS	Банкуудын гадаад гүйлгээний тайлан



1. УДИРТГАЛ

1.1. Судалгааны зорилго

Төлбөрийн тэнцлийн статистикийг боловсруулах олон улсын аргачлалын дагуу гадаад улсруу эмчлүүлэх зорилгоор аялсан эдийн засгийн харьяат иргэдийн зарцуулсан зардлыг² аялал жуулчлалын үйлчилгээний дэд дансанд бүртгэдэг. Манай улс энэхүү зардлыг банкуудын гадаад гүйлгээний тайлангийн мэдээлэл болон эмчлүүлэгчдийн бэлэн мөнгөөр төлсөн зардлын таамаг тооцоонд үндэслэн тооцож байна.

Эмчлүүлэгчдийн бэлэн мөнгөөр төлсөн зардлын таамаг тооцоог 2013 онд БНСУ, БНХАУ, Тайланд улсын холбогдох байгууллагуудаас авсан тоон мэдээлэлд үндэслэн тооцсон бөгөөд энэхүү судалгааны ажлын хүрээнд мэдээллийн эх сурвалжийг нэмэгдүүлэх замаар таамаг тооцоог баталгаажуулж, сайжруулахыг зорилоо.

1.2. Судлагдсан байдал

Монголбанк (2005). Алтанбулаг, Замын-Үүд боомтоор дамжин гадаад улсруу эмчлүүлэх зорилгоор аялж буй 380 зорчигчоос түүвэр судалгаа авахад иргэдийн 76% нь БНХАУ-руу, үлдсэн 24% нь ОХУ-руу зорчиж байсан бөгөөд нэг иргэн дунджаар **3270** ам.долларыг эмчилгээнд зарцуулахаар төлөвлөж байна гэж тогтоосон. Судалгаанд онгоцоор аялж буй иргэдийг хамруулж чадаагүй тул тооцоо дутуу үнэлэгдсэн байна.

Монголбанк (2013). БНСУ, БНХАУ-д суугаа Монгол Улсын элчин сайдын яамд болон Тайланд улсын Төвбанк-аар дамжуулан тус улсын эрүүл мэндийн байгууллагаас авсан түүвэр судалгаанд үндэслэн дараах таамаг тооцоог гаргасан. Үүнд:

- БНСУ-д 2010, 2011 онд манай улсын 1860, 3266 иргэн эмчлүүлсэн, нэг эмчлүүлэгчийн дундаж зардал харгалзан 2161, 2153 ам.доллар буюу нийт 4.0, 7.0 сая ам.долларыг;
- БНХАУ-д жилд дунджаар 9000 иргэн эмчлүүлж, нэг эмчлүүлэгчийн дундаж зардал 2378 ам.доллар буюу нийт зардал 21 сая ам.долларыг;
- Тайланд улсад манай улсын иргэд 2011, 2012 онд харгалзан нийт 3.2, 3.7 сая ам.долларын зардлыг тус тус зарцуулсан.

Улмаар судалгааны дээрх дүн болон тухайн улсруу шилжүүлсэн банкуудын гадаад гүйлгээний дүнгийн зөрүүгээр эмчлүүлэгчдийн бэлэн мөнгөөр төлсөн зардлыг тооцож, энэхүү таамаг тооцоог 2015 оны 2 дугаар улирал хүртэлх төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлд ашигласан.

Эрүүл мэндийн хөгжлийн төв (2013). 2012 оны 7, 8 дугаар сард галт тэрэг, нисэх онгоцоор аялах гэж буй нийт 2824 зорчигчийн дунд түүвэр судалгааг зохион байгуулахад 4.6% буюу 130 зорчигч нь гадаадад эмчлүүлэх зорилгоор аялж байсан бөгөөд нэг эмчлүүлэгчийн дундаж зардал нь эмчилгээ, оношилгооны төрөл тус бүрээс хамаарч харилцан адилгүй ба жигнэсэн дунджаар **6381** ам.доллар байна гэж тогтоосон.

Судалгаанд гадаад улсад эмчилгээ хийлгэсэн Монгол иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, эрх зүйн зохицуулалт байхгүй, зөвхөн гадаад оронд эмчлүүлэхээр улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн тоон мэдээллээр эрүүл мэндийн статистикийн мэдээлэл хязгаарлагддаг гэж дүгнэсэн байна.

² Олон улсын тээврийн зардлыг хассан дүнгээр. Уг зардал нь төлбөрийн тэнцлийн тээврийн дансанд бүртгэгддэг.

2. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2.1. Мэдээллийн эх сурвалж

Монгол Улсын эрүүл мэнд, аялал жуулчлын салбарын үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлж буй ҮСХ-ны Статистикийн эмхэтгэл, ЭМХТ-ийн Эрүүл мэндийн статистикийн мэдээ болон ИХШХЕГ-ын Гадаадад зорчсон Монгол иргэдийн мэдээний алинд нь ч гадаад улсад эмчлүүлэгчдийн тоо мэдээлэл байдаггүй. Тиймээс түүвэр судалгаагаар тогтоосон гадаад улсад зорчин эмчлүүлэгч нэг эмчлүүлэгчийн дундаж зардлын дүнг ашиглан нийт зардлыг тодорхойлох боломжгүй болж байна.

Иймд энэхүү судалгааны зорилгод хүрэхийн тулд дараах хүснэгтэд үзүүлсэн эх сурвалжуудаас гадаадад эмчлүүлэгчдийн тоо (**Q**), нэг эмчлүүлэгчийн дундаж зардал (**AC**), нийт зардал (**TC**)-ын мэдээллүүдийг цуглуулж, харьцуулсан шинжилгээ, нэмэлт тооцооллыг хийлээ:

Хүснэгт 1. Судалгааны мэдээллийн эх сурвалжууд

№	Эх сурвалж	Мэдээллийн төрөл
1	Банкуудын гадаад гүйлгээний тайлан (Монголбанк 2011-2015);	TC
2	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ҮСХ 2011-2015);	TC, AC
3	Гадаадад аялж буй Монгол иргэдийн зардлын түүвэр судалгаа (Монголбанк 2014);	AC
4	Гадаадад эмчлүүлэгчдийн судалгаа (Эрүүл мэндийн хөгжлийн төв 2013);	AC, Q
5	Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн мэдээ (Эрүүл мэнд, спортын яам);	Q
6	Гадаад улсын эрүүл мэндийн байгууллагуудын мэдээ ³ (МУ-ын ЭСЯ 2013, 2015);	TC, Q, AC
7	Гадаадын эмнэлгийн төлөөлөгчийн газруудын мэдээ ⁴ (2015);	TC, Q, AC
8	Гадаад улсын төв банкуудын мэдээ ⁵ (2015);	TC

2.2. Банкуудын гадаад гүйлгээний тайлан

Төлбөрийн тэнцлийн статистикийн гол эх сурвалж болох банкуудын гадаад гүйлгээний тайланд тусгагдсан эмчилгээний төлбөртэй холбоотой сүүлийн 5 жилийн шилжүүлгийн дүнг судлахад, төлбөр хүлээн авагч улсуудын хувьд БНСУ 29%, БНХАУ 20%, Сингапур 17%, АНУ 11%-ийг тус тус эзлэх бөгөөд нийт дүнгээрээ 2012 онд хамгийн их буюу **13.9** сая ам.долларыг эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрт зарцуулсан бол эдийн засгийн өсөлтийн хурд буурсан 2013, 2014 онуудад гүйлгээний хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Банкны системээр төлөгдсөн эмчилгээний зардал (мян. ам.доллар)

Он	2011	2012	2013	2014	2015 эхний 7 сар	Эзлэх хувь
1 БНСУ	1,153	3,013	3,621	4,137	1,590	28.5%
2 БНХАУ	2,265	2,648	2,035	1,431	1,276	20.4%
3 Сингапур	429	4,781	1,725	825	397	17.2%
4 АНУ	1,398	1,136	1,235	1,201	343	11.2%
5 Герман	225	387	263	563	364	3.8%
6 Япон	89	226	396	339	476	3.2%
7 ОХУ	104	24	291	416	199	2.2%
8 Энэтхэг	68	151	179	132	43	1.2%
9 Вьетнам	34	65	144	155	100	1.0%
10 Тайланд	89	35	46	47	19	0.5%
11 Бусад	677	1,434	1,468	724	756	10.7%
Нийт	6,530	13,900	11,403	9,969	5,562	100.0%

³ АНУ, БНАСАУ, БНСУ, БНХАУ, Канад, Куба, Индонези, Их Британи, ОХУ, Франц, Энэтхэг улсад суугаа ЭСЯ.

⁴ БНСУ-ын Гүми гандун, Сон, Энэтхэг улсын Аполло, Герман улсын Хэлиос эмнэлэг.

⁵ АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Сингапур, Хонгконг, Тайланд, Энэтхэг, Япон улс.

2.3. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Үндэсний статистикийн хороо нь жил бүр өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг дэлгэрэнгүй болон хураангуй судалгааны анкетаар ээлжлэн гүйцэтгэдэг бөгөөд өрхүүдийг гадаад улсруу эмчилгээнд явсан эсэхийг тодорхойлох асуултууд зөвхөн дэлгэрэнгүй судалгааны анкетанд тусгагддаг байна. Хамгийн сүүлийн дэлгэрэнгүй судалгаанд 2012, 2014 онд харгалзан 12 мянга, 16 мянган өрх хамрагдаж, үүнээс 17, 24 иргэн гадаад улсруу эмчилгээнд явсан гэж мэдээлсэн ба эмчилгээ, үйлчилгээний төлбөрт нэг иргэн дунджаар **6381, 4820** ам.долларыг зарцуулсан тооцоо гарч байна. Статистикийн аргачлалын дагуу түүврийн үр дүнг Монгол Улсын нийт өрхүүдийн хэмжээнд тархааснаар манай улс 2012 онд **3.4** сая, 2014 онд **10.1** сая ам.долларыг гадаадын эмчилгээ, үйлчилгээний төлбөрт зарцуулсан гэж тайланд тусгажээ.

2.4. Гадаадад аялсан Монгол иргэдийн зардлын түүвэр судалгаа

2014 онд Монголбанк, АЖҮТ, НАЖГ хамтран нисэх онгоцоор гадаад улсад аялаад ирсэн 697 зорчигчийг санамсаргүй түүвэрлэн судалгаа авахад, 12% буюу 84 иргэн эмчлүүлэх зорилгоор аялж, тэдний 49% нь БНСУ, 25% нь БНХАУ, 7% нь Тайланд, 5% нь Энэтхэг улсад тус тус эмчлүүлээд ирсэн гэж мэдээлжээ. Судалгаагаар нэг эмчлүүлэгч дунджаар БНСУ-д 11 хоногт 4502 ам.доллар, БНХАУ-д 13 хоногт 2066 ам.доллар, Тайланд улсад 20 хоногт 3414 ам.доллар, Энэтхэг улсад 17 хоногт 2863 ам.долларыг тус тус зарцуулсан болохыг тогтоов.

2.5. Гадаадад эмчлүүлэгчдийн судалгаа

2012 онд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс галт тэрэг, нисэх онгоцоор аялах гэж байсан 2824 зорчигчийг санамсаргүй түүврээр судалгаа авахад, 4.6% буюу 130 зорчигч нь эмчлүүлэх зорилготой аялагчид байсан бөгөөд нэг эмчлүүлэгч дунджаар 6381 ам.доллар зарцуулахаар төлөвлөж байна гэсэн үр дүн гарчээ. Мөн эмчилгээний төрлүүдээс шалтгаалж зардлын дүн маш өндөр зөрүүтэй, тухайлбал мэс засалд орох иргэд хамгийн их буюу дунджаар 22805 ам.доллар, амбулаторийн үзлэг, шинжилгээнд орох иргэд хамгийн бага буюу 1761 ам.долларыг зарцуулахаар төлөвлөж байгааг тогтоов.


2.6. Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн мэдээ

Эрүүл мэнд, спортын яаманд гадаад улсуудад эмчилгээний зорилготой аялсан иргэдийн тоо, зардлын талаарх статистик, мэдээлэл байхгүй, зөвхөн улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн мэдээлэл байх ба тус мэдээгээр 2011-2014 онд жилд дунджаар 152 иргэнд 330 мянган ам.долларыг гадаадад эмчлүүлэгчдэд олгосон тоо баримт байна.

Дүрслэл 1. Санхүүгийн дэмжлэгийн дүн, иргэдийн тоо



Дүрслэл 2. Эмчилгээ, үйлчилгээ авсан улс (2015)



Эмчлүүлэгчдийн зорьсон улсыг нь авч үзвэл 2015 оны эхний 8 сарын байдлаар БНСУ 39%, Энэтхэг 31%, БНХАУ 17%, Тайланд 7%-ийг эзэлж байна.



2.7. Гадаад улсын эрүүл мэндийн байгууллагуудын мэдээ

Монголбанк нь 2013, 2015 онд Гадаад хэргийн яам болон АНУ, БНАСАУ, БНСУ, БНХАУ, Индонези, Их Британи, Канад, Куба, ОХУ, Франц, Энэтхэг улсад суугаа элчин сайдын яам, консулын газруудаас тухайн улсруу эмчилгээний зорилгоор аялсан нийт Монгол иргэдийн мэдээллийг тус улсын холбогдох эрүүл мэндийн байгууллагуудаас авч ирүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. БНСУ, БНХАУ, Энэтхэг улсаас судалгаанд ашиглах боломжтой мэдээллийг ирүүлж, харин бусад улсаас тус улсад эмчлүүлэх зорилготой аялагчид төдийлөн ирдэггүй гэж мэдээлсэн болно.

2.8. Эмнэлгийн төлөөлөгчийн газруудын мэдээ

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй гадаадын эмнэлгийн төлөөлөгчийн газрууд нь УБЕГ, ҮСХ-ны мэдээллийн санд төлөөлөгчийн газрын ангиллаар бус худалдаа, үйлчилгээний компанийн ангиллаар бүртгэгдсэн байх тул тухайн байгууллагуудын нарийн тоог тогтооход хүндрэлтэй байна. Харин цахим мэдээллийн хэрэгслээр манай улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 5 улсын 8 эмнэлгийн төлөөлөгчийн газрийн мэдээлэл байх бөдгээр тэдгээр нь өөрсдийн эмнэлгээ танилцуулах, холбоо тогтоож өгөх, виз авахад зөвлөгөө, туслалцаа үзүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлдэг байна.

Энэхүү түүвэр судалгааны хүрээнд дээрх 8 төлөөлөгчийн газраас мэдээлэл хүсэхэд, БНСУ-ын 2, Энэтхэг улсын 1, Германы 1 буюу нийт 5 газраас судалгааны асуулгын дагуу мэдээллийг ирүүлж, харин Тайланд, Сингапур улсын эмнэлгийн төлөөлөгчийн газраас тус улсруу аялахад виз авдаггүй учир эмчлүүлэгчидийн бүртгэл байхгүй хэмээн мэдээлэл өгөхөөс татгалзсан.

2.9. Гадаад улсын төв банкуудын мэдээ

Монголбанк нь АНУ, БНХАУ, БНСУ, ОХУ, Сингапур, Тайланд, Хонгконг, Энэтхэг, Япон улсын төлбөрийн тэнцлийн статистик гаргадаг төв банк болон статистикийн байгууллагуудаас Монгол иргэдийн эмчилгээний төлбөрийн талаар мэдээлэл хүсэхэд зөвхөн Тайланд улсаас 2011, 2012 оны тоон мэдээллийг хүлээн авч, бусад улсаас энэ төрлийн тоон мэдээлэл байхгүй гэсэн албан хариуг авсан.

3. ТАЙЛАН, МЭДЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ


Энэ хэсэгт тайлан мэдээ, статистик, судалгааны үр дүнг харьцуулж, ялгаатай мэдээллийн шалтгааныг судлан тодруулахыг зорилоо.

Гадаад улсад эмчлүүлэгчдийн нийт зардлыг банкны гадаад гүйлгээ, ӨНЭЗС-ны тайлангийн дүнг харьцуулбал, 2008, 2011, 2014 оны үр дүн нийцтэй, бусад онд нэлээд зөрүүтэй байна.

Банкуудын гадаад гүйлгээний тайланд гадаадад эмчлүүлэгчдийн банкаар шилжүүлсэн буюу бэлэн бус төлбөрийг бүртгэдэг ба үүнд бэлэн мөнгөөр төлсөн зардлын дүн ордоггүй.

ӨНЭЗС-гаар бэлэн болон бэлэн бус нийт төлбөрийн мэдээллийг авах хэдий ч түүвэрт хамрагдсан өрхүүдийн зардлыг Монгол Улсын нийт иргэдийн хэмжээнд тархааж боддог.

Дүрслэл 3. Гадаад улсад эмчлүүлэгчдийн нийт зардал (Банкны гадаад гүйлгээний тайлан, ӨНЭЗС-ны үр дүн)



2012, 2014 оны судалгаанд харгалзан 12, 16 мянган өрх хамрагдснаас ердөө 0.15% нь буюу 17, 24 өрх гадаад улсад эмчлүүлсэн гэж мэдээлсэн ба түүврийн хэмжээ ийнхүү хэтэрхий бага байгаа тул эмчлүүлэх зорилгоор аялсан нийт Монгол иргэдийг төлөөлж чадахгүй. ӨНЭЗС нь нийт зардал (бэлэн, бэлэн бус)-ын дүн тул банкны гадаад гүйлгээний дүнгээс ямагт их байх ёстой, гэвч эсрэг үр дүнг үзүүлсэн нь түүврийн чанарт эргэлзэхэд хүргэж байна. (Дүрслэл 3)

Түүнчлэн ӨНЭЗС, Монголбанк, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн түүвэр судалгаануудын үр дүнд гарсан дундаж зардал харилцан адилгүй байна. Энэ нь нийт эмчлүүлэгчийн тоо тодорхой бус тул түүврийн эх олонлогоо төлөөлөх чадвар эргэлзээтэй, иргэдийн эмчилгээ, оношилгооны төрөл, үйлчлүүлсэн улсаас хамаарч нэлээд ялгаатай байдагтай холбоотой юм. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Гадаадад эмчлүүлэгчдийн дундаж зардал, судалгаа тус бүрээр

Судалгаа	Он	Үр дүн (ам.доллар)	Түүврийн хэмжээ	Судалгаа авсан байршил	Эмчлүүлсэн улс
Монголбанк	2005	3,270	380	Галт тэрэг	БНХАУ, ОХУ
ӨНЭЗС	2012	2,888	17	Өрхүүд	Тодорхойгүй
ЭМХТ	2012	6,381	130	Галт тэрэг, Онгоц	БНХАУ, БНСУ, Тайланд
Монголбанк	2014	4,820	84	Онгоц	БНХАУ, БНСУ, Тайланд, Энэтхэг
ӨНЭЗС	2014	7,207	24	Өрхүүд	Тодорхойгүй

Тайлан, судалгаанууд зардлыг ийнхүү нэлээд зөрүүтэй тооцон мэдээлэх хэдий ч Монгол иргэд эмчилгээний зорилгоор аялахдаа ихэвчлэн БНСУ, БНХАУ, Тайланд, Энэтхэг улсыг сонгодог болохыг нотлох тул эдгээр улсын мэдээлэлд анхаарал хандуулж цаашдын тооцооллыг хийх нь илүү үр дүнтэй юм.

4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Гадаад улсад эмчлүүлэгч иргэдийн дийлэнхи нь БНСУ, БНХАУ, Тайланд, Энэтхэг улсад зорчин эмчлүүлдэг ба улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан эмчлүүлэгчдийн 94%,

банкуудын гадаад гүйлгээгээр хийгдсэн эмчилгээний төлбөрийн шилжүүлгийн 51% нь эдгээр улсад хамаарч байна. Иймд эдгээр 4 улс тус бүрийн хувьд эмчилгээний зорилгоор аялж буй иргэдийн нийт зардлыг дараах байдлаар тооцов.

4.1. БНСУ

Эмчлүүлэгчдийн тоо. БНСУ-ын Эрүүл мэнд, худалдаа, хөгжлийн институт (ЭМХХИ)-ийн судалгаанд Монгол улсаас тус улсыг зорин эмчлүүлэгчид нь эмчилгээний болон богино хугацаатай жуулчлалын визээр зорчдог бөгөөд 2009, 2010, 2011 онд харгалзан 850, 1860, 3266 иргэн эмчлүүлсэн гэж мэдээлжээ. Энэ нь тус улсад аялсан манай улсын нийт жуулчдын 18%-ыг эзэлж бөгөөд энэ харьцааг 2012-2015 онд хадгалагдана гэж таамаглав.

Дундаж зардал. Судалгаанд аялагчдын зардлыг 2009, 2010, 2011 онд харгалзан 1.3 сая, 4.0 сая, 7.0 сая ам.доллар гэж мэдээлжээ. Эндээс нэг эмчлүүлэгчийн тус улсад зарцуулсан дундаж зардал 2010, 2011 онд харгалзан 2943, 3439 ам.доллар буюу жилийн дундаж өсөлт 11% байсныг харж болох бөгөөд энэхүү өсөлт нь 2012-2015 онд хадгалагдана гэж таамаглав.

Дээрх таамаг тооцоогоор 2014 оны дундаж зардал 4706 ам.доллар байх ба энэ нь Монголбанкны түүвэр судалгаа, эмнэлгийн төлөөлөгчийн газрын мэдээтэй⁶ ойролцоо түвшинд байгаа нь цаашид ашиглах боломжтойг илтгэж байна.

Төлбөрийн тэнцлийн 2012-2015 оны гүйцэтгэлд тусгах эмчилгээний нийт зардлын дүнг дээрх таамаглалаар тооцсон эмчлүүлэгчийн тоо, дундаж зардлын үржвэрээр тооцов. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Эмчилгээний нийт зардлын тооцоо

	2011	2012	2013	2014	2015 эхний 7 сар
Эмчлүүлэгчдийн тоо	3,266	4,590	4,906	4,729	2,499
БНСУ-ын Эрүүл мэнд худалдаа, хөгжлийн институт	3,266				
Таамаг тооцоо (жуулчдын 18%)		4,590	4,906	4,729	2,499
Нэг эмчлүүлэгчийн дундаж зардал	3,439	3,818	4,239	4,706	5,225
БНСУ-ын Эрүүл мэнд худалдаа, хөгжлийн институт	3,439				
Түүвэр судалгаа		7,583		4,502	
Таамаг тооцоо (жилийн өсөлт 11%)		3,818	4,239	4,706	5,225
Эмчилгээний нийт зардал (мян. ам.доллар)	7,033	17,524	20,794	22,252	13,055

4.2. БНХАУ

Эмчлүүлэгчдийн тоо. БНХАУ-д суугаа ЭСЯ-наас 2013 онд манай улсын 7800 орчим иргэн, үүнээс 6191 иргэн буюу 79% нь Хөт хотод эмчлүүлсэн тухай мэдээлжээ. Мөн 2011-2014 онд Хөх хотод эмчлүүлэгч иргэдийн тоог ирүүлсэн тул Монголбанкнаас дээрх 79%-ийн харьцаа нь бусад онд хадгалагдана гэж таамаглан тус улсад эмчлүүлэгч нийт иргэний тоог гаргав.

Таамаг тооцоогоор 2014 онд эмчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оноос буурч байгаа нь тус улсруу банкаар шилжүүлсэн эмчилгээний төлбөр тооцооны бууралттай нийцтэй байна.

Дундаж зардал. ЭСЯ-наас зөвхөн 2012, 2013 оны зардлын мэдээллийг ирүүлсэн ба энэ нь Монголбанк, ЭМХТ-ийн түүвэр судалгаануудын үр дүн ойролцоо утгай байна. Тиймээс ЭСЯ-

⁶ БНСУ-ын эмнэлгийн төлөөлөгчийн газрын мэдээнд дундаж зардал 4750 ам.доллар байв

ны 2012 оны мэдээг тооцоонд сонгон авч, бусад оны дундаж зардлыг БНХАУ-ын инфляцийн түвшнээр үржүүлж таамаглав.

Төлбөрийн тэнцлийн 2011 болон 2013-2015 оны гүйцэтгэлд тусгах эмчилгээний нийт зардлын дүнг дээрх таамаглалаар тооцсон эмчлүүлэгчийн тоо, дундаж зардлын үржвэрээр тооцов.

Хүснэгт 5. Эмчилгээний нийт зардлын тооцоо

	2011	2012	2013	2014	2015 эхний 7 сар
Эмчлүүлэгчдийн тоо	7,771	7,936	7,800	6,568	3,831
Элчин сайдын яам			7,800		
Элчин сайдын яам (Хөх хот)	6,168	6,299	6,191	5,213	3,041
Таамаг тооцоо (Хөх хот /БНХАУ-д эзлэх хувь 79%)	7,771	7,936		6,568	3,831
Нэг эмчлүүлэгчийн дундаж зардал	2,703	2,774	2,847	2,912	2,985
Элчин сайдын яам		2,774	2,442		
Түүвэр судалгаа		2,995		2,066	
Таамаг тооцоо (БНХАУ-ын инфляци)	2,703		2,847	2,912	2,985
Эмчилгээний нийт зардал (мян. ам.доллар)	21,003	22,017	22,207	19,124	11,435

4.3. Тайланд

Эмчлүүлэгчдийн тоо. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн судалгаагаар Тайланд улсын хамгийн том Бумрунгранд эмнэлэгт 2011 онд манай улсын 1254 иргэн эмчлүүлсэн байна. Энэ нь тус улсруу зорчсон аялагчдын 4%-тай тэнцүү байх бөгөөд энэ харьцааг 2013-2015 онд хадгалагдана гэж таамаглав.

Дундаж зардал. Тайландын төв банк, эмнэлгийн төлөөлөгчийн газрын мэдээллээс тооцоход, 2011, 2012 оны нэг эмчлүүлэгчийн дундаж зардал харгалзан 2585, 2663 ам.доллар (нийт 3.2 сая, 3.7 сая ам.доллар) байх бөгөөд 2013-2015 оны зардлыг Тайланд улсын инфляцийн түвшнээр үржүүлж таамаглав. Төлбөрийн тэнцлийн 2013-2015 оны гүйцэтгэл дэх эмчилгээний нийт зардлыг энэхүү таамаглалаар тооцсон эмчлүүлэгчийн тоо, дундаж зардлын үржвэрээр тооцов.

Хүснэгт 6. Эмчилгээний нийт зардлын тооцоо

	2011	2012	2013	2014	2015 эхний 7 сар
Эмчлүүлэгчдийн тоо	1,254	1,408	2,311	1,611	403
Эмнэлгийн төлөөлөгчийн газар	1,254	1,408			
Таамаг тооцоо (жуулчдын 4%)			2,311	1,611	403
Нэг эмчлүүлэгчийн дундаж зардал	2,585	2,663	2,721	2,777	2,831
Тайландын төв банк, эмнэлгийн ТГ □	2,585	2,663			
Таамаг тооцоо (Тайланд улсын инфляци)			2,721	2,777	2,831
Эмчилгээний нийт зардал (мян. ам.доллар)	3,242	3,749	6,287	4,474	1,141
Тайландын төв банк □	3,242	3,749			

4.4. Энэтхэг

Эмчлүүлэгчдийн тоо. ЭСЯ-наас ирүүлсэн тус улсын эрүүл мэндийн байгууллагуудын судалгаанд 2011-2014 онд эмчлүүлсэн Монгол иргэдийн тоог мэдээлсэн. Энэ тоо нь тухайн улсруу зорчсон нийт аялагчдын 0.4%-ийг эзлэх ба харьцааг цаашид хадгалагдана гэж таамаглав.



Дундаж зардал. Судалгаанаас 2011-2014 оны дундаж зардлын дүнг тооцож, харин 2015 оны дундаж зардлыг Энэтхэг улсын инфляцийн түвшнээр үржүүлж таамаглав.

Дундаж зардлын хэмжээ бусад улсаас их байгаа нь манай иргэд ихэнхдээ өндөр өртөгтэй хагалгаанд орох зорилгоор тус улсыг зорьдогтой холбоотой юм. Жишээ нь элэг шилжүүлэн суулгах хагалгаа 44000-48000 ам.доллар, зүрхний хагалгаа 6000-9500 ам.доллар, тархи мэдрэлийн хагалгаа 9500 ам.долларын өртөгтэй байдаг.


Хүснэгт 7. Эмчилгээний нийт зардлын тооцоо

	2011	2012	2013	2014	2015 эхний 7 сар
Эмчлүүлэгчдийн тоо	76	135	172	202	51
Элчин сайдын яам	76	135	172	202	
Таамаг тооцоо (жуулчдын 0.4%)					51
Нэг эмчлүүлэгчийн дундаж зардал	2,763	22,333	22,500	20,871	22,426
Элчин сайдын яам	2,763	22,333	22,500	20,871	
Таамаг тооцоо (Энэтхэг улсын инфляци)					22,426
Эмчилгээний нийт зардал (мян. ам.доллар)	210	3,015	3,870	4,216	1,133

4.5. Төлбөрийн тэнцлийн статистикт

Энэхүү судалгааны хүрээнд хүлээн авсан мэдээлэл болон таамаг тооцоогоор 2011-2014 онд **БНСУ, БНХАУ, Тайланд, Энэтхэг** улсад эмчлүүлэгч Монгол иргэдийн тоо жилд дунджаар 13684, нийт зардлын дүн 45 сая ам.доллар байна. (Дүрслэл 4, 5)

Дүрслэл 4. БНСУ, БНХАУ, Тайланд, Энэтхэг улсад эмчлүүлэгчдийн тоо



Дүрслэл 5. БНСУ, БНХАУ, Тайланд, Энэтхэг улсад төлсөн эмчилгээний зардал



Дээрх 4 улсруу банкаар дамжуулан төлсөн эмчилгээний төлбөрийн гадаад гүйлгээний тоо жилд дунджаар 712, нийт төлбөрийн дүн 5.2 сая ам.доллар байгаа нь судалгаагаар тооцсон эмчлүүлэгчдийн тоо, зардлын дүнгээс харгалзан 19, 9 дахин бага байна. Иймд судалгааны хамрах хүрээ нь хангалттай буюу статистикт ашиглах боломжтой гэж үзлээ.


Эмчлүүлэгчид нь эмчилгээний үйлчилгээний төлбөр тооцооныхоо дунджаар 12 хувийг бэлэн мөнгөөр гүйцэтгэж байна гэсэн үр дүн гарсан байна.

Бусад улсад эмчилгээний зорилгоор аялсан иргэдийн мэдээллийн хувьд банкаар дамжуулж жилд дунджаар 342 удаагийн гүйлгээгээр нийт 5.2 сая ам.долларыг эмчилгээний төлбөрт шилжүүлсэн тухай мэдээллийг гадаад гүйлгээний тайлангаас харж болно. Харин бэлэн мөнгөөр төлбөр тооцоогоо хийсэн эмчлүүлэгчдийн тоо, нийт төлбөрийн дүнгийн талаарх мэдээллийн эх сурвалж байхгүй.


Тиймээс БНСУ, БНХАУ, Тайланд, Энэтхэг улсад аялсан эмчлүүлэгчдийн тоо болон гадаад гүйлгээний харьцаа нь бусад улсын хувьд ч хадгалагдана гэж таамаглав. Харьцааг ашиглан бусад улсруу банкаар шилжүүлсэн гадаад гүйлгээний мэдэгдэж буй дүнгээс эмчлүүлэгчдийн тоог тооцов. (Дүрслэл 6)

Нэг эмчлүүлэгчийн дундаж зардлыг ойролцоо утга бүхий БНСУ, БНХАУ, Тайланд улсын зардлын дунджаар 3182 ам.доллар гэж таамаглавал, нийт зардал жилд дунджаар 13.2 сая ам.доллар байх тооцоо гарч байна. Энэхүү зардлын дүн нь бэлэн болон бэлэн бус төлбөр (банкуудын гадаад гүйлгээ)-ийг нийтэд нь илэрхийлнэ. (Дүрслэл 7)

Дүрслэл 6. Бусад улсад эмчлүүлэгчдийн тоо




Дүрслэл 7. Бусад улсад төлсөн эмчилгээний зардал




Дээрх тооцооллыг нэгтгэвэл, 2011-2014 онд харгалзан 16, 20, 19, 16 мянган иргэн гадаад улсад эмчилгээний зорилгоор аялсан бөгөөд эмчилгээ, үйлчилгээний төлбөрт 42 сая, 64 сая, 66 сая, 60 сая ам.долларыг тус тус зарцуулсан таамаг тооцоог хийв. Зардлыг Монгол Улсын төлбөрийн тэнцлийн аяллын үйлчилгээний дансны эмчилгээний зорилготой аяллын дэд дансны дебит талд бүртгэнэ.

Дүрслэл 8. Эмчлүүлэгчдийн нийт тоо



Дүрслэл 9. Эмчилгээний нийт зардал





5. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар гадаад улсруу эмчилгээний зорилгоор аялсан Монгол иргэдийн нийт зардлыг тооцоолох зорилгоор банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад улсад суугаа элчин сайдын яамд, аяллын зардлын түүвэр судалгаанууд, гадаадын эмнэлгийн төлөөлөгчийн газрууд, Эрүүл мэнд, спортын яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн тоон мэдээллийг түүвэрлэн судаллаа.

Судалгааны үр дүнд гадаад улсруу эмчлүүлэх зорилгоор аялж буй Монгол иргэд ихэвчлэн БНСУ, БНХАУ, Тайланд, Энэтхэг улсуудад эмчлүүлдэг бөгөөд 2011-2014 онд жилийн дунджаар тус улсуудад эмчлүүлэгчдийн тоо 13684, зардлын дүн 45 сая ам.доллар байна. Мөн бусад улсад эмчлүүлсэн дүнг нэмж тооцоолбол нийт зардал 58 сая ам.доллар байна. Энд бусад улсруу эмчлүүлэх зорилгоор аялсан иргэдийн тоо мэдэгдэхгүй байгаа тул бэлэн мөнгөөр төлсөн төлбөрийн дүн дутуу үнэлэгдсэн байх магадлалтай.

Цаашид Төлбөрийн тэнцэл, Аялал жуулчлал, Эрүүл мэндийн статистикийн бодит байдлыг сайжруулахын тулд ҮСХ, ЭМСЯ, ИХШХЕГ-ын статистикт Монгол Улсаас гадаадад эмчлүүлэх зорилгоор аялсан иргэдийн тоог тогтмол мэдээллэж байх, энэ төрлийн тайланг гадаадын эмнэлгийн төлөөлөгчийн газруудаас хүлээн авах эрх зүйн зохицуулалтыг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.